ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ТАНИЛЦУУЛГА

MONTHLY BULLETIN OF STATISTICS

**2020/01**



**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН 2020 ОНЫ 01 САРЫН ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА**

**Эрдэнэт хот** **2020 он**

## 1.Макро эдийн засаг

### *Төсөв санхүү*

Аймгийн төсөвт 10.5 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 120.1 хувьтай байна. Татварын орлогын төлөвлөгөө 38.6 хувиар давж биелсэн байна.




Орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилтийн 24.8 хувийг буюу 4.8 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 0.3 хувийг хөрөнгийн зардалд, 2.4 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт, 8.1 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 26.6 хувийг бараа үйлчилгээний зардалд, 62.7 хувийг цалин хөлсөнд зарцуулжээ.

Салбарын хувьд ангилагдаагүй бусад зардалд 0.3 хувийг, эдийн засгийн бусад салбарт 1.0 хувийг, эрүүл мэнд, амралт спортын салбарт 5.1 хувийг, боловсрол, соёл урлагийн салбарт 30.6 хувийг, нийтийн ерөнхий үйлчилгээнд 62.9 хувийг зарцуулсан байна. Өмнөх оны мөн үеэс нийт зарлага санхүүжилт 10.0 хувиар буурч, орлого 28.9 хувиар нэмэгджээ.

### *Банк, мөнгө, зээл*

Иргэдийн хувийн мөнгөн хадгаламж 320.2 тэрбум төгрөгт хүрч, аймгийн нэг хүнд дунджаар 3067061 төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 3042034 төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үеэс хадгаламжийн үлдэгдэл 20.7 хувиар өсч, хадгаламж эзэмшигчийн тоо 6.4 хувиар буурчээ.

### *Ажил эрхлэлт*

Тайлант хугацаанд нийт 136 ажлын байр бий болсны 63.2 хувь нь шинэ ажлын байр байна.




Нийт ажлын байрны 5.1 хувь нь боловсролын салбарт, 6.6 хувь нь зочид буудал, зоогийн газарт, 12.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 14.7 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 32.4 хувь нь худалдааны салбарт, 28.7 хувь нь бусад салбарт бий болжээ.

Өмнөх оны мөн үеэс нийт бий болсон ажлын байр 41.7 хувиар, шинээр бий болсон ажлын байр 32.3 хувиар нэмэгджээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 1195 хүн бүртгэлтэй байгаагийн 57.1 хувь нь эмэгтэйчүүд ба бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буюу 30 хүнээр бага байна.

Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 34.4 хувь нь 25-34 насныхан, 27.9 хувь нь 35-44 насныхан, 19.8 хувь нь 45 ба түүнээс дээш насныхан, 17.8 хувь нь 15-24 насныхан байна. Тайлант хугацаанд бүртгэгдсэн ажилгүйчүүдийн 24.5 хувь нь сургууль төгссөн, 11.1 хувь нь өөр газраас шилжиж ирсэн, 4.8 хувь нь орон тооны цомхотголд орсон, 0.5 хувь нь байгууллага татан буугдсан, 59.1 хувь нь бусад шалтгаанаар ажил хайж бүртгүүлжээ.

## 2. Нийгмийн үзүүлэлт

### *<u>Нийгмийн халамж, даатгал</u>*

Аймгийн дүнгээр давхардсан тоогоор 24.8 мянган хүнд 7.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосноос 1.6 мянган хүнд 281.6 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, 1.7 мянган хүнд 147.6 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 355 хүнд 65.3 сая төгрөгийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 251 ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 32.4 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтээр 5.3 мянган хүнд 257.8 сая төгрөгийн тэтгэмж, хөнгөлөлт олгожээ. Өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 20.9 хувиар, олгосон халамжийн хэмжээ 8.2 хувиар бага байгаа нь өмнөх оны 1 дүгээр сард насны хишиг, алдарт эхийн одонтой эхчүүдийн тэтгэмж олгогдсонтой холбоотой.




Нийгмийн даатгалын сангийн орлогод 10.0 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 47.3 хувиар давж биелсэн байна. Ажилгүйдэл, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 6.8-17.4 хувиар тасарч, тэтгэмж, ҮОМШӨ, тэтгэврийн даатгалын сангийн орлого 15.4-74.8 хувиар давж биелжээ. Сангийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 30.7 хувиар буюу 2.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ сард 41 хүнд шинээр тэтгэвэр тогтоосноос 63.4 хувьд нь өндөр насны, 29.3 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 7.3 хувьд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоожээ. Тэтгэвэр тогтоолгосон хүний тоо өмнөх оны мөн үеэс 59.8 хувиар бага байна.

### <u>Эрүүл мэнд</u>

Эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 64.9 мянган хүнд үзлэг ийснээс 30.4 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Өмнөх оны мөн үеэс нийт үзлэг 9.2 хувиар нэмэгдэж, урьдчилан сэргийлэх үзлэг 1.0 хувиар буурчээ.

Сэргийлэх тарилгад нийт хамрагдвал зохих хүний 99.0 хувь буюу 1.5 мянган хүн хамрагдсан ба хамрагдалт өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр бага байна.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 216 эх амаржин, 50 хүн нас баржээ. Нийт нас баралтын 2.0 хувийг нялхсын нас баралт эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 10.0 промилээр буурч, 1000 хүнд ногдох нас баралт өмнөх оны мөн үеийн түвшинд байж, төрөлт 0.1 промилээр нэмэгджээ.




Халдварт өвчнөөр өвчилсөн 98 тохиолдол гарсан нь өмнөх оны мөн үеэс 42.0 хувиар буюу 2.7 продицимилээр нэмэгдсэн байна.

Өмнөх оны мөн үеэс 10000 хүнд ногдох мөөгөнцөр 0.2, суулгалт халдвар 0.6, цусан суулга 0.7 продицимилээр буурч, бусад өвчний гаралт 0.1-1.3 продицимилээр нэмэгдсэнээс салхинцэцэг өвчнөөр өвчилсөн тохиолдол 1.3 продицимилээр нэмэгджээ.

## Сахилга дэг журам

Цагдаагийн газрын мэдээгээр 70 хэрэгт 10 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 10.2 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс хэргийн илрүүлэлт 12.0 пунктээр, холбогдогч 23.1 хувиар буурч, бүртгэгдсэн хэрэг 22.8 хувиар, 18–аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 1.8 продицимилээр нэмэгджээ.




Өмнөх оны мөн үеэс хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг хэрэг 80.0 хувиар, хулгайлах хэрэг 10.0 хувиар буурч, малын хулгай өмнөх оны мөн үеийн түвшинд байж, бусад хэргийн гаралт 16.7%-3.0 дахин нэмэгдсэнээс хүчингийн хэрэг 3.0 дахин нэмэгджээ.

| | **2020** |
|---|---|
| Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг | 70 |
| Үүнээс: хэрэг бүртгэлтийн хэрэг *(эзэнгүй хэрэг)* | 59 |
| Илрүүлэлтийн хувь | 10.2 |
| Гэмт хэрэг үйлдэгсэд | 10 |

**Бүртгэгдсэн гэмт хэрэг,** хэргийн өнгөөр

| | |
|---|---|
| Хүнийг алах | - |
| Хүчиндэх | 3 |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 26 |
| Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг | 1 |
| Хулгайлах | 9 |
| Дээрэмдэх | 3 |
| Залилах, хөрөнгө завших | 13 |
| Авлигын хэрэг | - |
| Мал хулгайлах | 1 |
| Бусад | 14 |

Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 229.3 сая төгрөгийн хохирол учирч, 7 хүн нас барж, 27 хүн гэмтсэн ба нийт хохирлын 13.2 хувийг нь нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт холбогдсон 10 хүний 70.0 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 60.0 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байсан 130 жолоочийг илрүүлэн, зөрчил гаргасан 107 жолоочийн эрхийг тодорхой хугацаагаар хасч шийтгэжээ. Өмнөх оны мөн үеэс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон жолоочийн тоо 25.0 хувиар, эрх хасалт 20.2 хувиар нэмэгджээ.

## 3.Үйлдвэрлэл үйлчилгээ.

### *Аж үйлдвэр*

Аж үйлдвэрийн салбарт 189.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 197.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 1.4 хувиар өсч, борлуулалт 0.1 хувиар буурсан байна.

сая.төг

| Аж үйлдвэрийн салбар | 2016- I сар | 2017- I сар | 2018- I сар | 2019- I сар | 2020- I сар | 2020 / 2019 % |
|---|---|---|---|---|---|---|
| Үйлдвэрлэлт | 89 133.5 | 157 465.5 | 201 638.9 | 186 349.9 | 188 964.0 | 101.4 |
| Борлуулалт | 94 204.7 | 172 441.5 | 215 407.2 | 197 548.4 | 197 422.9 | 99.9 |

Нийт бүтээгдэхүүний 99.98 хувь нь Баян-Өндөр суманд, 0.02 хувь нь Жаргалант суманд үйлдвэрлэгджээ.

Өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 1.4 хувиар, цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт 2.9 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 22.1 хувиар өссөн байна.

Нийт бүтээгдэхүүний 91.3 хувийг уул уурхайн олборлох, 6.3 хувийг боловсруулах, 2.4 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэжээ.







Гол нэр төрлийн 58 бүтээгдэхүүнийг судалгаанд хамруулснаас хэрчсэн гурил, цахилгаан эрчим хүч, хивс, дулааны эрчим хүч, молибдений баяжмал, банш, бууз, хулдаасан хэвлэл, гоймон, талх, бялуу, лед чийдэн, хөшиг, цэвэр ус, ганбөмбөлөг, 1.1-97.0 хувиар, зайрмаг, ноолууран алчуур, тараг, дайвар бүтээгдэхүүн, буриад гутал, боловсруулсан шингэн сүү, тэмээний ноосон хөнжил, суудлын бүрээс, бетон зуурмаг,

хонины мах, металл бэлдэц 3.1-16.1 дахин өсч, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 0.8-97.9 хувиар буурсаны дотор хэвийн боов 97.9 хувиар буурчээ.

## Хөдөө аж ахуй

Тайлант хугацаанд 1 толгой том мал зүй бусаар хорогдож, мал онд оролт 99.99 хувьтай ба өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Жаргалант суманд 1 том мал хорогдсон байна.

| | õýì æèõ í ýãæ | 2016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | | 2020/2019 % |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Òî | Î í û ýõí èé ì àëä ýçëýõ õóâü | Òî | Î í û ýõí èé ì àëä ýçëýõ õóâü | Òî | Î í û ýõí èé ì àëä ýçëýõ õóâü | Òî | Î í û ýõí èé ì àëä ýçëýõ õóâü | Òî | Î í û ýõí èé ì àëä ýçëýõ õóâü | |
| Ì àë î í ä î ðî ëò | õóâü | 99.98 | | 99.97 | | 99.57 | | 99.99 | | 99.99 | | 0.0 |
| Ç¿é áóñ õî ðî ãäî ë | òî | 24 | 0.018 | 41 | 0.03 | 520 | 0.43 | 9 | 0.01 | 1 | 0.001 | 11.1 |

**Том малын зүй бус хорогдол**, толгой




## Барилга

Оны эхний 1 дүгээр сард их барилгын салбарт 1 аж ахуй нэгж 1.7 тэрбум төгрөгийн барилга засварын ажлыг 4 объектод хийж гүйцэтгэсэн байна. Гүйцэтгэсэн ажлын дүн өмнөх оны мөн үеэс 5.2 дахин нэмэгджээ.

**Барилга угсралт, их засварын ажлын дүн**, тэрбум төгрөг



## Тээвэр, холбоо

Òýýâðèéí áàéãóóëëàãóóä 11.5 ì ÿí /òí  à÷àà òýýâýðëýí , 4.3 ñàÿ.òí /êì -èéí  à÷àà ýðãýëò, 0.4 сая çî ð÷èã÷ òýýâýðëýí , 5.5 ñàÿ õ¿í /êì –èéí  çî ð÷èã÷ ýðãýëò õèéæ, òýýâðèéí ¿éë÷èëãýýí ýýñ 1.4 тэрбум òº ãðº ãèéí  î ðëî ãî òî é àæèëëàсан байна.




Өмнөх оны мөн үеэс тээсэн зорчигч 20.6, зорчигч эргэлт 43.9 хувиар буурчээ. Çî ð÷èã÷ òýýâðèéí ¿éë÷èëãýýí ä 407 òàêñè, 4 ì èêðî àâòî áóñ, 54 автобус гарч, тэдгээрт 668 хүн ажиллаж байна.




Холбооны байгууллагууд 749.9 сая төгрөгийн тарифын орлоготой ажилласны 98.1 хувь нь хүн амын үйлчилгээний орлого байна. Өмнөх оны мөн үеэс мэдээлэл холбооны сүлжээний орлого 4.9 хувиар, интернэтийн орлого 12.5 хувиар, үүрэн телефоны орлого 21.1 хувиар, кабелийн телевизийн орлого 29.6 хувиар өсч, монголын цахилгаан холбооны орлого 20.0 хувиар буурч, төмөр замын холбооны орлого өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Интернэт үйлчилгээний 2 цэг давхардсан тоогоор 1.7 мянган хүнд үйлчилгээ үзүүлжээ.

## *Худалдаа, үйлчилгээ*

Худалдаа, нийтийн хоолны 613 цэг салбар 10.2 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийж, бараа гүйлгээний нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар нэмэгджээ.




Нийт бараа гүйлгээний 38.4 хувийг хүнсний дэлгүүр, 29.4 хувийг шатахууны борлуулалт, 13.9 хувийг зоогийн газар, 9.7 хувийг эм борлуулалт, 7.2 хувийг барааны дэлгүүр, 0.6 хувийг авто засварын газар, 0.4 хувийг контейнер, 0.3 хувийг барилгын материалын дэлгүүр, 0.1 хувийг авто сэлбэгийн дэлгүүрийн орлого эзэлж байна.

Өмнөх оны мөн үеэс хүнсний дэлгүүр, авто сэлбэгийн дэлгүүр, эм борлуулалт, авто засварын газрын орлого 6.7-97.3 хувиар, ТҮЦ-ний орлого 14.9 дахин өсч, зоогийн газрын орлого 4.4 хувиар, шатахуун борлуулалт 7.5 хувиар, контейнерийн орлого 14.1 хувиар, барааны дэлгүүрийн орлого 23.9 хувиар, барилгын материалын дэлгүүрийн орлого 46.1 хувиар буурчээ.

Аймгийн зоогийн газрын 111 цэг салбар 1.4 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар, үүнээс ресторан, баарны орлого 5.6 хувиар буурчээ.

Нийтийн хоолны бараа гүйлгээний 49.6 хувийг ресторан, баарны орлого эзэлж байна.

Нийт бараа гүйлгээний 98.4 хувь нь Баян-Өндөр суманд хийгджээ.

## *Нийтийн аж ахуйн үйлчилгээ*

Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлого 2.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар нэмэгджээ. Нийт орлогын 46.0 хувийг орон сууцны, 45.6 хувийг аж ахуйн нэгж албан газрын, 6.0 хувийг зочид буудлын, 1.2 хувийг зөөврийн цэвэр ус борлуулалтын, 0.8 хувийг хог тээвэрлэлтийн, 0.3 хувийг сауны, 0.2 хувийг халуун усны орлого бүрдүүлж байна.




Өмнөх оны мөн үеэс орон сууц, зөөврийн цэвэр ус борлуулалт, аж ахуйн нэгж, албан газар, зочид буудлын орлого 16.8–28.2 хувиар нэмэгдэж, халуун ус, хог тээвэрлэлт, сауны орлого 33.3 – 77.3 хувиар буурчээ.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний нийт орлогын 99.5 хувийг Баян-Өндөр сум эзэлж байна.

Ахуйн үйлчилгээний салбарын дүнгээр 143.3 сая төгрөгийн үйлчилгээг үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар нэмэгджээ.

Нийт орлогын 47.3 хувийг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, 35.9 хувийг үсчин, 9.2 хувийг хими цэвэрлэгээ, 2.9 хувийг прокат ба тоглоомын цэг, 2.4 хувийг гутал засвар, 1.8 хувийг гэрэл зураг, 0.4 хувийг телевизор засвар, 0.1 хувийг цаг засварын орлого эзэлж байна.




Ахуйн үйлчилгээний орлогын 99.7 хувийг Баян-Өндөр сум бүрдүүлдэг ба Жаргалант суманд 2 үсчин үйл ажиллагаа явуулж байна.

## *Бусад мэдээлэл*

Байгаль цаг агаарын хувьд сарын дундаж температур -13.5 хэмийн хүйтэн байж, өмнөх оны мөн үеэс 1.7 хэмээр дулаан, хур тунадас 0.9 мм-ээр бага байна.

Агаарын чанарын MNS4585:2016 стандартад харьцуулан үзэхэд азотын давхар исэл(NO2) болон хүхэрлэг хий (SO2), нүүрстөрөгчийн дутуу исэл(CO) стандартаас давсан байна. 2019 оны 1 сартай харьцуулахад 2-р харуул дээрх хүхэрлэг хийн агууламж 0.6 дахин нэмэгдсэн байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | | | 2020 / 2019 % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт | |
| **Нийт орлого** | **4 021.1** | **6 570.4** | **6 438.5** | **8 135.5** | **8 737.9** | **10 490.4** | **120.1** | **128.9** |
| Урсгал орлого | 4 021.1 | 6 570.4 | 6 438.5 | 8 135.5 | 8 737.9 | 10 490.4 | 120.1 | 128.9 |
| Татварын орлого | 1 288.0 | 3 745.3 | 3 462.5 | 4 806.6 | 4 787.5 | 6 634.0 | 138.6 | 138.0 |
| Орлогын албан татвар | 469.1 | 2 013.2 | 2 087.3 | 3 283.4 | 2 555.0 | 4 145.2 | 162.2 | 126.2 |
| - Хүн амын орлогын албан татвар | 469.1 | 2 013.2 | 2 087.3 | 3 283.4 | 2 555.0 | 4 145.2 | 162.2 | 126.2 |
| Үүнээс: Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал | - | 1 919.5 | 1 897.6 | 2 745.2 | 2 300.0 | 3 581.0 | 155.7 | 130.4 |
| - Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | - | - | - | - | - | - | - | - |
| Хөрөнгийн албан татвар | 712.7 | 726.6 | 632.1 | 703.2 | 750.5 | 709.0 | 94.5 | 100.8 |
| Бусад татвар | 106.2 | 1 005.5 | 743.1 | 820.0 | 1 482.0 | 1 779.8 | 120.1 | 2.2 [2] |
| Татварын бус орлого | 2 733.1 | 2 825.1 | 2 976.0 | 3 328.9 | 3 950.4 | 3 856.4 | 97.6 | 115.8 |

Тайлбар: [2] - Дахин их

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, зардлаар, сая төгрөг

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | | | 2020/2019 % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| **Нийт зардал** | **3 937.7** | **3 980.7** | **3 678.8** | **5 306.5** | **19 288.1** | **4 775.7** | **24.8** | **90.0** |
| Цалин хөлс | 1 862.6 | 1 913.7 | 1 938.3 | 2 457.7 | 3 192.8 | 2 993.3 | 93.8 | 121.8 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 199.5 | 211.0 | 214.8 | 313.7 | 426.6 | 387.2 | 90.8 | 123.4 |
| Бараа үйлчилгээний зардал | 958.2 | 886.4 | 707.1 | 1 992.2 | 5 064.2 | 1 268.1 | 25.0 | 63.7 |
| Татаас ба урсгал шилжүүлэг | 917.4 | 969.6 | 809.2 | 118.7 | 2 766.0 | 112.6 | 4.1 | 94.9 |
| Хөрөнгийн зардал | - | - | 9.4 | 424.2 | 7 807.9 | 14.5 | 0.2 | 3.4 |
| Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | - | - | - | - | 30.6 | - | - | |

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, салбараар, сая төгрөг

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | | | 2020/2019 % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| **Нийт зардал** | **3 937.7** | **3 980.7** | **3 678.8** | **5 306.5** | **19 288.1** | **4 775.7** | **24.8** | **90.0** |
| Нийтийн ерөнхий үйлчилгээ | 1 018.0 | 916.7 | 770.2 | 2 261.5 | 7 498.5 | 1 462.4 | 19.5 | 64.7 |
| Боловсрол, соёл урлаг | 1 840.0 | 2 024.7 | 1 991.9 | 2 397.9 | 3 634.6 | 3 006.2 | 82.7 | 125.4 |
| Эрүүл мэнд, спорт | 131.0 | 120.6 | 135.6 | 168.7 | 247.6 | 245.1 | 99.0 | 145.3 |
| Нийгмийн даатгал, нийгмийн халамж | 917.4 | 890.0 | 737.7 | 6.2 | 10.7 | - | - | - |
| Эдийн засгийн бусад салбарт | 31.3 | 28.7 | 34.0 | 48.0 | 88.8 | 47.5 | 53.5 | 99.0 |
| Ангилагдаагүй бусад зардал | - | - | 9.4 | 424.2 | 7 807.9 | 14.5 | 0.2 | 3.4 |

БАНКНЫ МЭДЭЭЛЭЛ, сая төгрөг

| | | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2020/2019 % |
|---|---|---|---|---|---|---|---|
| Кассын орлого | МБ-ны зузаатгалаар | 11 103.1 | 7 081.5 | 7 814.9 | 12 493.4 | - | - |
| | Гүйлгээнээс татсан | 105 855.6 | 117 646.2 | 139 110.1 | 159 573.5 | - | - |
| Кассын зарлага | МБ-нд шилжүүлсэн | 8 122.3 | 9 076.3 | 9 935.5 | 6 651.4 | - | - |
| | Гүйлгээнд гаргасан | 107 453.9 | 120 593.4 | 139 542.6 | 162 804.0 | - | - |
| Зээлийн өрийн үлдэгдэл | | 206 512.6 | 223 445.7 | 259 893.3 | 344 308.5 | 343 066.2 | 99.6 |
| | Хугацаа хэтэрсэн зээл | 3 479.8 | 2 478.3 | 2 947.0 | 3 553.3 | 6 225.7 | 175.2 |
| | *Зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь* | 1.7 | 1.1 | 1.1 | 1.0 | 1.8 | 0.8 |
| | Чанаргүй зээл | 2 867.8 | 5 484.9 | 3 871.2 | 6 448.5 | 5 790.4 | 89.8 |
| | *Зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь* | 1.4 | 2.5 | 1.5 | 1.9 | 1.7 | -0.2 |
| Хөдөлмөрчдийн мөнгөн хадгаламж | | 136 235.1 | 180 122.5 | 206 272.3 | 265 396.6 | 320 238.0 | 120.7 |
| 1 хүнд ногдох хадгаламж (мян.төг) | | 1 443.2 | 1 767.8 | 2 029.2 | 2 586.2 | 3 067.1 | 118.6 |
| 1 хадгаламж эзэмшигчид ногдох хадгаламж (мян.төг) | | 1 291.3 | 1 631.3 | 1 900.7 | 2 359.8 | 3 042.0 | 128.9 |

Тайлбар: * Монгол улсын Төрийн болон албаны нууцын тухай хуулиар байгууллагын нууцын жагсаалтанд орсон учир мэдээлэл гарахгүй.

НИЙТ БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР, *эдийн засгийн салбараар*

| Эдийн засгийн салбар | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | шинээр бий болсон |
|---|---|---|---|---|---|---|
| **БҮГД** | **50** | **47** | **18** | **96** | **136** | **86** |
| ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 4 | - | - | - | - | - |
| Уул уурхай, олборлолт | - | - | - | - | 16 | 15 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 6 | 2 | 7 | 11 | 17 | - |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | - | - | - | - | - | - |
| Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | - | - | - | - | 4 | 4 |
| Барилга | 3 | - | - | - | 6 | 6 |
| Бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ | 1 | - | 4 | 6 | 44 | 42 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | - | - | 1 | - | 1 | 1 |
| Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | - | 1 | 2 | 37 | 9 | 9 |
| Мэдээлэл, холбоо | - | - | - | - | - | - |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | - | 1 | - | 7 | - | - |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | - | - | - | - | - | - |
| Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 12 | - | - | 1 | - | - |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | - | 16 | - | 12 | - | - |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал | - | 8 | - | 2 | 6 | 3 |
| Боловсрол | 19 | 14 | 1 | 2 | 7 | 1 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | - | 3 | - | 6 | 3 | 2 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 1 | - | - | - | 3 | - |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 4 | 2 | 3 | 12 | 20 | 3 |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ | - | - | - | - | - | - |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | - | - | - | - | - | - |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээгээр авав.

## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2020/2019 % |
|---|---|---|---|---|---|---|
| **БҮГД** | **2 688** | **1 719** | **1 475** | **1 225** | **1 195** | **97.6** |
| *эмэгтэй* | 1 494 | 906 | 789 | 692 | 682 | 98.6 |
| Ажилгүйчүүд насны бүлгээр | | | | | | |
| 15 - 24 | 683 | 310 | 299 | 212 | 213 | 100.5 |
| 25 - 34 | 1 123 | 716 | 571 | 438 | 411 | 93.8 |
| 35 - 44 | 518 | 370 | 326 | 311 | 334 | 107.4 |
| 45 - 60 | 364 | 323 | 279 | 264 | 237 | 89.8 |

## НИЙТ БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2020/2019 % |
|---|---|---|---|---|---|---|
| **БҮГД** | **50** | **47** | **18** | **96** | **136** | **141.7** |
| *эмэгтэй* | 31 | 30 | 14 | 72 | 100 | 138.9 |
| Төрийн, төсөвт байгууллага | 30 | 38 | 1 | 11 | 13 | 118.2 |
| Компани, нөхөрлөл | 16 | 9 | 11 | 72 | 89 | 123.6 |
| Хоршоо | - | - | - | - | - | |
| Бусад | 4 | - | 6 | 13 | 34 | 2.6[2] |

**Тайлбар:** [2]-Дахин их

## ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН АЖИЛГҮЙЧҮҮД

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2020/2019 % |
|---|---|---|---|---|---|---|
| Нэмэгдсэн ажилгүйчүүд | 553 | 313 | 518 | 302 | 208 | 68.9 |
| *эмэгтэй* | 345 | 199 | 266 | 181 | 128 | 70.7 |
| Орон тооны цомхотголоос | 43 | 72 | 38 | 9 | 10 | 111.1 |
| Байгууллага татан буугдсанаас | 14 | 5 | 8 | 4 | 1 | 25.0 |
| Өөр газраас шилжин ирсэн | 20 | 28 | 42 | 57 | 23 | 40.4 |
| Сургууль төгссөн | 338 | 65 | 203 | 63 | 51 | 81.0 |
| Цэргээс халагдсан | - | 1 | 5 | 2 | 1 | 50.0 |
| Цалин багатайгаас | 28 | 16 | 51 | 22 | 22 | 100.0 |
| Бусад | 110 | 126 | 171 | 145 | 100 | 69.0 |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээгээр авав.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, *сая төгрөг*

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | | | 2020/2019 % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Т | Г | % | |
| **Орлогын дүн** | **4 389.4** | **4 168.4** | **5 340.1** | **7 658.5** | **6 794.8** | **10 008.6** | **147.3** | **130.7** |
| Тэтгэвэр | 2 699.5 | 2 562.9 | 3 301.7 | 4 852.7 | 4 331.2 | 7 570.3 | 174.8 | 156.0 |
| Тэтгэмж | 300.1 | 284.1 | 374.2 | 559.7 | 424.8 | 490.2 | 115.4 | 87.6 |
| ҮОМШӨ | 522.9 | 488.6 | 619.0 | 787.1 | 530.0 | 689.1 | 130.0 | 87.5 |
| Ажилгүйдэл | 79.5 | 72.8 | 86.8 | 121.2 | 114.6 | 106.8 | 93.2 | 88.1 |
| Эрүүл мэндийн даатгал | 787.4 | 760.0 | 958.4 | 1 337.8 | 1 394.2 | 1 152.2 | 82.6 | 86.1 |
| **Зарлагын дүн** | **5 297.7** | **6 779.9** | **6 028.9** | **9 457.5** | **9 182.3** | **9 599.4** | **104.5** | **101.5** |
| Тэтгэвэрт | 4 228.4 | 5 935.0 | 5 186.3 | 6 885.1 | 7 238.8 | 6 959.8 | 96.1 | 101.1 |
| Тэтгэмж | 373.0 | 309.3 | 186.2 | 428.4 | 677.5 | 587.9 | 86.8 | 137.2 |
| Эрүүл мэндийн даатгал | 306.3 | 123.5 | 249.0 | 1 337.8 | 838.9 | 1 152.3 | 137.4 | 86.1 |
| ҮОМШӨ | 310.3 | 339.3 | 299.8 | 695.6 | 312.5 | 792.6 | 2.5[2] | 113.9 |
| Ажилгүйдэл | 79.7 | 72.8 | 107.6 | 110.6 | 114.6 | 106.8 | 93.2 | 96.6 |
| **Тэтгэвэр авагчдын тоо** | **13 190** | **14 041** | **14 592** | **14 905** | **-** | **15 601** | **-** | **104.7** |
| *~өндөр нас* | 9 138 | 10 059 | 10 635 | 11 312 | - | 11 887 | - | 105.1 |
| *~хөгжлийн бэрхшээлтэй иргэн* | 3 143 | 3 117 | 3 103 | 2 832 | - | 2 936 | - | 103.7 |
| *~тэжээгчээ алдагч* | 909 | 865 | 854 | 761 | - | 778 | - | 102.2 |
| **Тухайн сард тэтгэврийн мөнгөө авсан хүний тоо** | **13 185** | **14 041** | **14 394** | **14 905** | **-** | **14 999** | **-** | **100.6** |
| *~өндөр нас* | 9 136 | 10 059 | 10 641 | 11 312 | - | 11 527 | - | 101.9 |
| *~хөгжлийн бэрхшээлтэй иргэн* | 3 141 | 3 117 | 2 955 | 2 832 | - | 2 744 | - | 96.9 |
| *~тэжээгчээ алдагч* | 908 | 865 | 798 | 761 | - | 728 | - | 95.7 |
| **Тэтгэвэр тогтоогдсон хүний тоо** | **151** | **100** | **106** | **102** | **-** | **41** | **-** | **40.2** |
| *~өндөр нас* | 85 | 66 | 58 | 81 | - | 26 | - | 32.1 |
| *~хөгжлийн бэрхшээлтэй иргэн* | 57 | 30 | 40 | 18 | - | 12 | - | 66.7 |
| *~тэжээгчээ алдагч* | 9 | 4 | 8 | 3 | - | 3 | - | 100.0 |

Тайлбар: [2] -Дахин их

| | Хүний тоо | | | | | 2020/2019 % | Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж (*сая.төг*) | | | | | 2020/2019 % |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | |
| БҮГД | **4 792** | **5 388** | **4 798** | **16 381** | **9 154** | **55.9** | **437.5** | **440.6** | **364.8** | **1 554.6** | **784.7** | **50.5** |
| **Халамжийн тэтгэвэр** | **1 512** | **1 479** | **1 347** | **1 761** | **1 570** | **89.2** | **198.9** | **211.9** | **183.4** | **251.3** | **281.6** | **112.1** |
| **Нөхцөлт мөнгөн тэтгэмж** | **1 324** | **1 558** | **1 334** | **1 457** | **1 712** | **117.5** | **80.0** | **100.3** | **81.3** | **114.7** | **147.6** | **128.7** |
| Ахмад настныг асарч буй иргэнд | 630 | 781 | 662 | 694 | 869 | 125.2 | 38.3 | 50.0 | 39.9 | 52.0 | 68.1 | 131.0 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд | 635 | 721 | 623 | 708 | 784 | 110.7 | 37.5 | 46.1 | 37.9 | 56.0 | 73.9 | 132.0 |
| Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигчид | 40 | 45 | 40 | 53 | 42 | 79.2 | 2.8 | 3.4 | 3.0 | 5.3 | 3.9 | 73.6 |
| Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа | 16 | 11 | 9 | 1 | 16 | 16.0[2] | 1.2 | 0.8 | 0.5 | 0.7 | 1.6 | 2.2[2] |
| Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа | 2 | - | - | 1 | - | - | 0.1 | - | - | 0.7 | - | - |
| Хүүхэд, төрөл садангүй, ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ асран хамгаалж байгаа | 1 | - | - | - | 1 | - | 0.1 | - | - | - | 0.1 | - |
| **Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж** | **233** | **304** | **332** | **328** | **355** | **108.2** | **37.0** | **45.2** | **43.8** | **56.6** | **65.3** | **115.4** |
| Байнгын асаргаа шаардлагатай иргэнд | 4 | 28 | 49 | 2 | - | - | 0.3 | 0.5 | 0.5 | 0.1 | - | - |
| 16 хүртлэх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж | 223 | 265 | 279 | 322 | 353 | 109.6 | 27.9 | 36.7 | 38.9 | 50.1 | 61.3 | 122.4 |
| 3 ба түүнээс дээш тооны (14 хүртэлх насны) хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа | - | 4 | - | - | - | - | - | 0.5 | - | - | - | - |
| 2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж | 2 | 2 | 2 | 2 | 2 | 100.0 | 4.0 | 4.0 | 2.0 | 4.0 | 4.0 | 100.0 |
| 4 хүртлэх насны 3 ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа иргэнд | - | - | - | - | - | | - | - | - | - | - | - |
| Нэг удаагийн тусламж | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Хорих ангиас суллагдсан өөрийн орон гэргүй иргэнд | 1 | - | 1 | - | - | - | 1.2 | - | 1.2 | - | - | - |
| 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа | - | 2 | - | - | - | - | - | 1.2 | - | - | - | - |
| Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа | 3 | 3 | 1 | 2 | - | - | 3.6 | 2.4 | 1.2 | 2.4 | - | - |
| 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны Хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Ахмад настай, ХБИ-дэд олгосон тусламж, хөнгөлөлт** | **144** | **271** | **450** | **205** | **251** | **122.4** | **43.0** | **14.3** | **30.9** | **15.0** | **32.4** | **2.2[2]** |
| Ахмад настанд үзүүлсэн | 60 | 127 | 271 | 65 | 108 | 166.2 | 34.3 | 6.8 | 20.8 | 9.6 | 25.7 | 2.7[2] |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн | 84 | 144 | 179 | 140 | 143 | 102.1 | 8.7 | 7.5 | 10.1 | 5.4 | 6.7 | 124.1 |
| **Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилт** | **1 529** | **1 776** | **1 335** | **12 630** | **5 266** | **41.7** | **70.1** | **68.9** | **25.4** | **1 117.0** | **257.8** | **23.1** |
| Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн мөнгөн тэтгэмж | 1 494 | 1 776 | 1 297 | 656 | 865 | 131.9 | 63.7 | 68.9 | 19.0 | 26.2 | 33.6 | 128.2 |
| Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон мөнгөн тусламж | 1 | - | - | 4 173 | - | - | 0.2 | - | - | 555.9 | - | - |
| Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт | 34 | - | 38 | 45 | 50 | 111.1 | 6.2 | - | 6.4 | 7.2 | 8.2 | 113.9 |
| Насны хишиг | - | - | - | 3 819 | - | - | - | - | - | 329.6 | - | - |
| Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Цалинтай ээж хөтөлбөр | - | - | - | 3 937 | 4 351 | 110.5 | - | - | - | 198.1 | 216.0 | 109.0 |
| Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ** | 50 | - | - | - | - | - | 8.5 | - | - | - | - | - |

Тайлбар: [2] -Дахин их

| | 2016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | | Харьцуулсан хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бодит тоо | үзүү-лэлт | бодит тоо | үзүү-лэлт | бодит тоо | үзүү-лэлт | бодит тоо | үзүү-лэлт | бодит тоо | үзүү-лэлт | бодит тоо | үзүү-лэлт |
| **1000 хүнд ногдох** | | | | | | | | | | | | |
| Амаржсан эх | 197 | 2.1 | 184 | 1.8 | 211 | 2.1 | 202 | 2.0 | 216 | 2.1 | 106.9 | 0.1 |
| Төрөхийн улмаас эндсэн эх *(100 000 амьд төрөлтөд ногдох)* | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| Нас баралт | 49 | 0.5 | 43 | 0.4 | 32 | 0.3 | 54 | 0.5 | 50 | 0.5 | 92.6 | 0.0 |
| 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 6 | 30.1 | 1 | 5.5 | 1 | 4.7 | 3 | 14.6 | 1 | 4.6 | 33.3 | -10.0 |
| 1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| **10 000 хүнд ногдох** | | | | | | | | | | | | |
| **Халдварт өвчнөөр өвчлөгсөд** | **71** | **7.7** | **50** | **4.9** | **63** | **6.2** | **69** | **6.7** | **98** | **9.4** | **142.0** | **2.7** |
| Цусан суулга | 2 | 0.2 | 3 | 0.3 | 7 | 0.7 | 9 | 0.9 | 2 | 0.2 | 22.2 | -0.7 |
| Сальмонеллёз | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| Халдварт шар | - | - | 1 | 0.1 | - | - | 1 | 0.1 | - | - | | |
| Бруцеллез | - | - | - | - | 1 | 0.1 | - | - | - | - | | |
| Халдварт мэнэн | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| Сүрьеэ | 7 | 0.8 | 4 | 0.4 | 5 | 0.5 | 3 | 0.3 | 9 | 0.9 | 3.0[2] | 0.6 |
| Суулгалт халдвар | - | - | - | - | - | - | 8 | 0.8 | 2 | 0.2 | 25.0 | -0.6 |
| Хамуу | - | - | 1 | 0.1 | - | - | - | - | - | - | | |
| Заг хүйтэн | 2 | 0.2 | 1 | 0.1 | 3 | 0.3 | 4 | 0.4 | 10 | 1.0 | 2.5[2] | 0.6 |
| Тэмбүү | 14 | 1.5 | 10 | 1.0 | 13 | 1.3 | 13 | 1.3 | 21 | 2.0 | 161.5 | 0.7 |
| Мөөгөнцөр | 10 | 1.1 | 15 | 1.5 | 10 | 1.0 | 7 | 0.7 | 5 | 0.5 | 71.4 | -0.2 |
| Трихоманаз | 11 | 1.2 | 12 | 1.2 | 10 | 1.0 | 8 | 0.8 | 9 | 0.9 | 112.5 | 0.1 |
| Кандид | - | - | - | - | 4 | 0.4 | 7 | 0.7 | 16 | 1.5 | 2.3[2] | 0.8 |
| Салхинцэцэг | - | - | 3 | 0.3 | 8 | 0.8 | 9 | 0.9 | 23 | 2.2 | 2.6[2] | 1.3 |
| Гахай хавдар | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| Хоолны хордлого | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| Херпес вируст цэврүүт дэртатит | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| Гар, хөл, амны өвчин | - | - | - | - | 1 | 0.1 | - | - | 1 | 0.1 | | |
| Ёлом | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| Улаан бурхан | 24 | 2.6 | - | - | - | - | - | - | - | - | | |
| Улаанууд | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| Бүслүүр үлд | - | - | - | - | 1 | 0.1 | - | - | - | - | | |
| Улаан эсэргэнэ | 1 | 0.1 | - | - | - | - | - | - | - | - | | |
| Эмнэлгийн дотоод халдвар | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| *нярайн бактерит үжил* | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээгээр авав.

Тайлбар: [2]-Дахин их

ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2020/2019 % |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт үзлэг, хүн | 48 586 | 60 919 | 53 968 | 59 431 | 64 876 | 109.2 |
| урьдчилан сэргийлэх үзлэг | 15 129 | 16 656 | 16 902 | 19 949 | 19 740 | 99.0 |
| Нэг хүний эмнэлэгт үзүүлсэн тоо | 0.52 | 0.65 | 0.53 | 0.58 | 0.62 | 107.9 |
| Эмчлэгдсэн хүний тоо | 1 860 | 2 228 | 2 301 | 2 641 | 2 867 | 108.6 |
| Ор хоног | 14 758 | 16 517 | 16 781 | 17 519 | 19 839 | 113.2 |
